



Нисэх буудал дахь орогнол хайгчдад зориулсан мэдээлэлийн хуудас

Та дүрвээд Швейцар улсад орогнол хамгаалалт хайж байна уу? Швейцарийн дүрвэгсдийн тусламж SFH энэхүү мэдээлэлийн хуудасыг боловсруулан бичсэн. Энэ нь таньд нисэх буудал дахь цагаачлалтай холбогдсон чухал алхам шатуудыг тайлбарлаж өгнө.

Швейцарийн дүрвэгсдэд туслах байгууллага (SFH) нь төрийн бус байгууллага ба цагаач болон дүрвэгсдийн эрхийг хамгаалах ажил эрхэлдэг. Манай вэбсайт: www.osar.ch; Цагаач болон дүрвэгсдэд зориулсан мэдээлэл олон хэл дээр энэ вэбсайтад бий: www.for-refugees.ch

1. Орогнох өргөдөл гаргах

1.1 Нисэх буудал дээр цагаачлалын хүсэлт гаргах

Та орогнох өргөдөлөө Швейцар улсын нисэх онгоцны буудал дээр өгчээ.

- Орогнох хүсэлтийг шалгах явцын хугацааны турш (магадгүй зөвхөн эхний үед) та нисэх буудлын дамжин өнгөрүүлэх хэсэгт (Transitbereich) байрлана. **Анхаар:** Энэ шийдвэрийн эсрэг та гомдол гаргаж болно.
- Та өөрийн баримт бичиг болон гадаад паспортоо өгөх ёстой. Таниас түүнийг асууна.

Таныг орогнох өргөдөлөө өгсөний чинь дараа бүртгэж авч, фото зураг болон хурууны мөрийн хээг тань авна. Швейцарын албан байгууллагууд таны хурууны мөрийн хээг Европын нэгдсэн төв санд (Eurodac) Европын холбооны аль нэг орон юмуу Норвеги, Исландаас бүртгэгдэж үү гэдгийг шалгаж тогтооно. Хэрвээ та аль нэг оронд бүртгэгдсэн байх юм бол тухайн орон, таны гэр бүл, үр хүүхэд чинь Швейцарт амьдардагаас бусад тохиолдолд таны цагаачлахтай холбогдсон асуудлыг хариуцна. Ийм тохиолдолд Швейцар улс таныг тухайн хариуцсан Европын орон руу чинь гаргахыг хөөцөлдөнө. Дублины хэлэлцээрийн дагуу та Европын орнуудын хүрээнд зөвхөн нэг удаа цагаачлал хүсэх эрхтэй. Таны анхны хандсан орон таны орогнох хүсэлтийг хүлээн авч шалгаж үзэх ёстой. Хэрвээ та өмнө нь Европын ямар нэгэн оронд цагаачлах хүсэлт гаргасан бөгөөд тэр орон тань хүсэлтийг үнэн зөв шалгаагүй гэж үзэж байгаа бол та нисэх буудлын хууль зүйн зөвлөлгөө өгөх газар юмуу хуулийн төлөөлөгчид заавал хандах хэрэгтэй. Жишээ нь Швейцараас таныг буцаах гэж байгаа нөгөө гуравдагч Европын орон таны орогнол хайсан хүсэлтийг үл харгалзан, хэдийвээр таны хувьд орогнол хайж дүрвэх үндэслэл, нөхцөл бүрдсэн боловч үүнийг шалган магадлахгүйгээр шууд нутаг руу чинь буцаана гэж үзэж байгаа бол Швейцарт үлдэх боломж олгохыг шаардах хэрэгтэй. Мөн таныг Швейцараас буцаах Европын орон шууд цаашаа эх орон руу чинь буцаасан тохиолдолд танд тэнд хүний ёсонд нийцэхгүй торгууль, тамлалын

аюул нүүрлэж болзошгүй гэж айж байгаа бол Швейцарт үлдэх боломж олгохыг шаардана.

1.2 Бүртгэлт

Байгууллагууд таниас таны **биеийн байцаалт**, гэр бүлийн тань биеийн байцаалт, **ирсэн зам** болон **дүрэвсэн шалтгааныг** тань асуултад оруулж асууна.

Энэ асуулгын явцад төрийн ажилтан болон хэрэгцээтэй бол орчуулагч оролцоно.

- Эх ороноосоо яагаад гарах болсон бүх чухал үндэсээ нэрлэнэ үү.
- Таньд өөр хүнд ярьж болохооргүй юм тохиолдсон бол түүнийгээ ярьна уу.
- Та баримт бичигээ өгч чадахгүй байгаа бол үндэслэж тайлбарлана уу.
- Хэрэв та ямар нэг зүйл ойлгохгүй байвал түүнийгээ хэлнэ үү.

Асуулга болгоны эцэст та ярианы протоколд гарын үсэгээ зурна. Таны хариулт зөв, таны хэлсэн зүйл бүгд бүрэн эсэхийг нарийн шалгана уу.



1.3 Баримт бичиг / Нотолгоо

- Таныг мөрдөж байгааг баримтлах бичиг баримтыг актанд өгнө үү.
- Өгч байгаа бичиг баримтын фото хуулбарыг өөртөө авч үлдэж байна уу.

1.4 Тодруулалт


Таны байдалд нэмэлт тодруулалт хийж магадгүй:

- Хэрэв таныг хаанаас ирсэнд эргэлзээ байвал хэлний мэрэгжилтэнээр ирсэн улс, нутгийн тань талаар асуулгана.
- Хэрэв таны насанд тань эргэлзээ байвал тодруулалт хийлгэнэ.

1.5 Цаашид яах вэ?

Таниас нисэх буудал дахь цагаачлалын албаны ажилтнууд таны орогнол хайж байгаа шалтгаан үндэслэлийн талаар дахин өргөн хүрээтэй асууж лавлаад дараахь шийдвэрүүдийн нэгийг гаргана:

- Хүлээн авахийг татгалзсан шийдвэр, үүний эсрэг та гомдол гаргаж болно.
 - Цагаачлахыг татгалзсан сөрөг шийдвэр, үүний эсрэг та гомдол гаргаж болно.
 - Цагаачлах хүсэлтээ шийдвэрлүүлэхийн тулд Швейцар улс нутаг дэвсгэр рүү орохыг зөвшөөрнө. Ийм шийдвэр маш цөөн тохиолдолд олгогдоно.
- Таньд N-үнэмлэх (N-Ausweis) (цагаачдад зориулсан үнэмлэх) өгнө.



2. Асуулга

Асуулга нь орогнох хүсэлтийг шалгах явцад маш чухал. Та нэг эсвэл олон удаа асуулганд орж болно. Байгууллагууд нь таны орогнох өргөдөлийг дүгнэхдээ асуулга болон асуулгын протокол дээр тулгуурлана.

2.1 Асуулганд хэн оролцох вэ?

- Төрийн ажилтан асуулгыг удирдан явуулна.
- Орчуулагч бүтэн орчуулга хийнэ, таны тайлбарууд дүгнэлтгүй, товчлолгүй бичигдэнэ.
- Тусламжийн байгууллагын төлөөлөгч нэг хүн (төрийн бус байгууллагад ажилдаг хүн) орогнох хүсэлтийг шалгах явцыг ажиглана. Энэ хүн нь өөр асуулт тавиулах болон өөрийнхөө тусламжийн байгууллагад асуулгын тухай илтгэл мэдээлэл явуулж болно.
- Та өөрөө томилсон хуулийн төлөөлөгчөө эсвэл нэг насанд хүрсэн хүн (гэхдээ энэ хүн нь одоогоор орогнох өргөдөл өгсөн байж болохгүй) дагуулж ирж болно.

2.2 Асуултууд

Асуулгын явц дүрмээрээ ийм байдаг:

Бүх байгаа хүмүүстэй танилцуулсаны дараа тэдний эрх үүрэг ба асуулгын явцыг тайлбарлаад төрийн ажилтан таны хувийн байдлыг асууна:

- Таны биеийн байцаалт болон түүнийг батлах баримт бичиг
- Гэр бүлийн байдал ба хамаатан садны талаар
- Цэргийн алба
- Эх орноосоо Швейцарт ирсэн зам
- Эх орондоо болон Швейцарт ямар ажил хийж байсан ба одоо хийж байгаа
- Ямар гадаад улсад буудалсан
- Эх оронд дахь болон Швейцар улс дахь таны хуулийн төлөөлөгч

Эцэст нь танд та яагаад Швейцар улсад хамгаалалт орогнол хайж байгаагаа тайлбарлах боломж өгнө.

Дүрвэгсэд хуулийн дагуу орогнол хүлээж авна (Орогнуулалтын хуулийн 3 дугаар зүйл).

Дүрвэгч гэдэг нь эх орондоо эсвэл хамгийн сүүлд амьдарч байсан оронд арьс өнгө, шашин шүтлэг, улсын харяат байдал, нийгмийн ямар нэг бүлэгт хамааралтай байдалаараа эсвэл улс төрийн үзэл бодолоосоо болж ноцтой ад үзэгдэж байгаа эсвэл ийм дорд байдалд орж болзошгүй гэсэн үндэслэлтэй айдастай хүнийг хэлнэ. Ноцтой дорд байдалын тоонд түүний бие бялдар, амь нас, эрх чөлөөг аюултай байдалд болон тэсэхийн аргагүй сэтгэл санааны дарамтанд оруулж буй арга хэмжээнүүд багтана. Эмэгтэйчүүдийн тусгай дүрвэх шалтгааныг харгалзаж үзэх ёстой.

2.3 Швейцар улсад хамгаалалт хайх

Асуултын явцад та яагаад дүрэвсэн ба орогнол хайж байгаа шалтгаанаа илэрхийлэх ёстой. Та чөлөөтэй ба айлтгүй ярьж болно. Өрөөнд байгаа бүх хүмүүс үг хадгалах хатуу үүрэгтэй бөгөөд таны ярьсан зүйлийг цааш хэнд ч ярих эрхгүй.

Асуултын энэ хэсэг маш чухал. Таньд **эх орноосоо гарахад ямар хүчин зүйл болон хэн нөлөөлсөнийг ярих** хүсэлт тавина.

- Таны хариулт үнэн байх ёстой. Аль болох олон нарийн зүйлийг дурдаж ярина уу
- Хэрэв танд эрэгтэй эсвэл эмэгтэй хүнд хэлж ярьж чадахааргүй ямар нэг зүйл тохиолдсон бол тэр талаарх сэтгэгдлээ ярина уу.
- Таныг мөрдөж байгаа баримт бичгийг авчирна уу (цагдаагийн газарын дуудлага, шүүхийн шийдвэр, шоронгийн баримт бичиг, заналхийлсэн захиа, эмчийн гэрчилгээ, фото зураг зэрэг – өөртөө хуулбар авч үлдэнэ үү!).
- Хэрвээ та өмнө нь Европын ямар нэгэн оронд байсан бөгөөд тэр орон таныг эх орон руу чинь буцаасан тохиолдолд танд тэнд хүний ёсонд нийцэхгүй торгууль, тамлал, мөрдөн мөшгөгдөх аюул нүүрлэж болзошгүй гэж айж байгаа бол, энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлаж ярина уу.

Таньд **ойлгомжгүй, буруу ойлгосон ба авцалдаагүй зүйлээс** болж өөр асуултууд тавьж магадгүй. Таны хариултуудыг бичиж аваад таньд орчуулж өгөх ёстой.

2.4 Гэр бүлийнхнээс асуух

Гэр бүлийн гишүүдээс нэг нэгээр нь асууна. Хэрэв насанд хүрсэн гэр бүлийн гишүүн асуугдвал бусад нь өөр өрөөнд хүлээх ёстой. Хүүхдээс эцэг эхийн хажууд асуух ёстой, хэрэв ямар нэг эсрэг зүйл гарахгүй бол.



3. Протокол

Асуулга болгонд протокол хөтлөгдөнө. Асуулга болгоны дараа таньд протоколыг орчуулж өгнө. Таниас хуудас болгон дээр гарын үсэг зурахыг хүснэ

→ Хэрэв та ямар нэг зүйл ойлгохгүй бол хэлнэ үү. Протоколд таны хэлэх гэсэн зүйл яг тэмдэглэгдсэн байна уу, шалгана уу. Алдаа болон ойлгомжгүй зүйлийг хэлж засуулна уу.

Асуулгын эцэст таниас одоог болтол дурдаагүй Швейцар улсад байх өөр ямар шалтгаан байна вэ гэж дахин асууна. Та бүгдийг тоочсон болон протоколд таны хэлсэн зүйл үнэн зөв тэмдэглэгдсэнийг баталж гарын үсгээ зурах ёстой.

4. Цагаачлахтай холбогдсон шийдвэрүүд

Нисэх онгоцны буудал дээрх орогнох хүсэлтийг шалгах үйл ажиллагаа **хэдхэн өдөр эсвэл хэдэн долоо хоногоор** үргэлжилдэг. Хэрвээ Улсын цагаачлалын албаны шийдвэр 20 хоногийн дотор багтаж гараагүй тохиолдолд та Швейцарийн аль нэг муж улс руу орж болно. Нисэх буудал дээр 60 хоногоос илүү хугацаагаар байлгах ёсгүй. Та нисэх буудал дахь зөвлөлгөө өгдөг газруудтай (хаяг энэ бичгийн 5рт байгаа <http://www.fluechtlingshilfe.ch/aide/adresses-utiles>) эртнээс холбоо барина уу.

Улсын цагаачлалын албанаас та шийдвэр Герман, Франц эсвэл Итали хэл дээр хүлээн авна.


Нисэх онгоцны буудал дээрх орогнох хүсэлтийг шалгасны дагуу дараахь шийдвэрүүд гарч болно:

4.1 Швейцар улс руу орох зөвшөөрөл

Улсын цагаачлалын алба таны орогнох хүсэлтийг Швейцар улсын нутаг дэвсгэр дээр явуулахаар шийдвэр гаргажээ. Гэхдээ энэ нь орогнолын эрх олгож байгаа биш зөвхөн **Швейцар улсын нутаг дэвсгэр рүү орохыг зөвшөөрсөн** болно.

4.2 Түр зуурын авалт

Таны орогнол хайлтыг тань татгалзсан боловч таньд Швейцар улсад байх **F-зөвшөөрөл (F-Bewilligung)** өгч магадгүй. Энэ шийдвэр зөвхөн эх орон руу чинь буцаах зам заалт *боломжгүй* эсвэл их аюулын улмаас *тийш явуулахад хүнд* бол гарна. Жишээ нь иргэний дайны байдал эсвэл хүнд өвчин. Зөвшөөрөл энэ байдал сайжирмагц хүчингүй болно.



4.3 Сөрөг шийдвэр

Цагаачлалын үндэслэгдсэн сөрөг шийдвэр ба буцаан гаргах шийдвэр

Таны орогнол хайлтыг тань **татгалзсан ба** та Швейцар улсыг **орхин гарах ёстой**. Энэ тохилдолд та буцаж нисэхээсээ өмнө нисэх онгоцны буудлаас гарч болохгүй. Ийм шийдвэр гарах нөхцөл нь, хэрэв та– байгууллагуудын үзэж байгаагаар– таньд дүрвэх хангалттай үндэс шалтгаан байхгүй, эсвэл та өөрийн байдлаа итгэмжгүй ярьсан эсвэл нотолж чадаагүй байдал юм.

Үндэслэлгүй шийдвэр

(Хүлээж авахыг татгалзсан шийдвэр, Гуравдагч орон руу гаргах буюу Европын холбооны аль нэг орон юмуу Норвеги, Исланд руу гаргах)

Таны орогнол хайлтыг богино хугацааны асуултын дараа цаашид авч хэлэлцэхгүй, таныг Швейцар улсаас даруйхан гаргах болно. Ийм байдал үүсэх боломж нь:

- Хэрэв та Швейцарийн нисэх онгоцны буудал дээр орогнол хайсан хүсэлт гаргахаасаа өмнө Европын холбооны аль нэг орон юмуу Норвеги, Исландад байсан бол таны орогнол хайх хүсэлтийг, ирсэн зам г.м богино хугацааны асуулгаар товчилно. Үүнд тусламжийн байгууллагын төлөөлөгч оролцохгүй. Энэ тохиолдолд Швейцар улс таныг тухайн байсан орон руу чинь буюу таны орогнол хайх хүсэлтийг хариуцсан Европын орон руу буцаан гаргах болно.
- Хэрэв та Швейцарийн нисэх онгоцны буудал дээр орогнол хайсан хүсэлт гаргахаасаа өмнө өөр улсад байсан, тэнд амьдарч байсан эсвэл тэнд таны хамаатан садан амьдардаг.
- Хэрэв та Швейцар эсвэл Европын өөр нэг оронд орогнол хайж өргөдөл өгч байсан ба шинэ өөр орогнох шалтгаан хүчин төгөлдөр болгож чадахгүй байвал.
- Хэрэв та Швейцард хамгаалалт хайж биш өөр шалтгаанаар ирсэн бол (гэр бүлийн эсвэл эдийн засагийн асуудал).
- Хэрэв та өөрийн жинхэнэ биеийн байцаалтаа нуусан бол (худлаа нэр, худлаа төрсөн он, сар өдөр гэх мэт).
- Хэрэв та Швейцарын байгууллагуудтай хамтран ажиллах үүргээ гүйцэтгээгүй бол (жишээ нь асуултад ирээгүй).
- Хэрэв та иргэний үнэмлэхгүй, 48 цагийн дотор авчирч чадахгүй, үнэмшихээр уучлалт шалтгаан байхгүй ба таны дүрэвсэн шалтгаан байгууллагуудад үнэмшилгүй байвал.
- Хэрэв та Швейцарын байгууллагуудын мөрдлөгийн аюул осолгүй гэж үзэж байгаа орноос ирсэн ба тэндээс дүрэвсэн шалтгаан байгууллагуудад үнэмшилгүй байвал (Safe Country).
- Хэрэв та Швейцард хууль бусаар байж байгаад баригдсаны дараа орогнол хайх өргөдөл өгсөн ба таны дүрэвсэн шалтгаан байгууллагуудад үнэмшилгүй байвал.

Анхаар: Хэрэв та гомдол гаргаагүй эсвэл гаргасан гомдолыг тань татгалзсан бол та Швейцард хууль бусаар оршиж байна.


- Тэдний татгалзсан шалтгаанаас хамаарч та шийдвэр авмагцаа баривчлагдаж болох юм.

Хэрвээ та гомдол гаргасан бол ерөнхийдөө гомдолын хариу гартал Швейцар улсад үлдэх эрхтэй.

Анхаарагтун, **онцгой тохиолдол:** Хэрэв та Швейцард ирэхээсээ өмнө Европын холбооны аль нэг орон юмуу Норвеги, Исландад байсан бол тухайн орон таны цагаачлахтай холбогдсон асуудлыг хариуцаж шалгах ёстой. Ийм тохиолдолд та гомдолын дагуу хариу гартал Швейцар улсад үлдэх боломж олгохыг шаардаж болно. Энэ талаарх өөрийн байдлыг маш тодорхой, дэлгэрэнгүй үндэслэж тайлбарлах хэрэгтэй. Жишээ нь танд дараахь үндэслэлүүдээс байгаа бол та Швейцар улсад үлдэх боломж олгохыг шаардаж болно. Таныг буцаах гуравдагч Европын орон:

- шууд цаашаа эх орон руу чинь буцаасан тохиолдолд танд тэнд хүний ёсонд нийцэхгүй торгууль, тамлалын аюул нүүрлэж болзошгүй,
- таны орогнол хайсан хүсэлтийг үл харгалзан, хэдийвээр таны хувьд орогнол эрэгч дүрвэгчийн шалгуур, нөхцөл бүрдсэн боловч үүнийг шалган магадлахгүйгээр шууд нутаг руу чинь буцаана гэж үзэж байгаа.

Энэ тохиолдолд хэдийвээр таныг хариуцах Европын аль нэг орон руу гаргасан ч, таны гомдолын хариу энд Швейцар улсад шийдэгдэнэ. Та Улсын засаг захиргааны шүүхэд (Bundesverwaltungsgericht, хаяг нь энэ мэдээллийн төгсгөлд байгаа) гомдолын хариу шийдвэр хүлээж авах гадаад дахь өөрийн хаягаа үлдээх хэрэгтэй. Хэрвээ та энд хуулийн төлөөний хүнтэй бол түүнтэйгээ хэдий гадаадад байгаа ч гэсэн холбоотой байх хэрэгтэй. Ингэснээрээ танд Швейцар улсад эргэн орж ирэх талаар нааштай шийд гарсан тохиолдолд даруй мэдэгдэх боломжтой.



5. Гомдол

Улсын цагаачлалын албаны гаргасан орогнуулах шийдвэртэй санаа нийцэхгүй байвал гомдол бичиж доорх хаяг руу илгээж болно:

[Bundesverwaltungsgericht](#)

Postfach, CH-3000 Bern 14

Telefon +41 (0)58 705 26 26

Fax +41 (0)58 705 29 80

Нисэх онгоцны буудал дээр танд гомдол гаргахад зөвхөн **таван өдрийн хугацаанд** багтах ёстой.

Орогнуулалтын шийдвэрийн эцэст гомдол гаргавал **хэдэн өдрийн хугацаа байгааг** заасан байгаа, «**Эрх зүйн талын мэдээлэл**» гэсэн бүлэгт – (5аас 30 хоног).

Хуулийн зөвлөлгөөний газар эсвэл өмгөөлөгч таньд тус болж болох юм (хаягийн жагсаалт энэ вэбсайтад үзнэ үү: <http://www.for-refugees.ch>). Швейцарийн дүрвэгсдэд туслах байгууллага SFH нэмж гомдол гаргах заавар <http://www.fluechtlingshilfe.ch/aide/fiches-d-information> өгнө.

Нисэх онгоцны буудлын хуулийн зөвлөлгөө өгөх газрын хаяг:

Zürich-Kloten

SRK, Sozial-, Rechtsberatung, Transit ZH-Airport,

Tel. 043 816 57 82, Fax 043 816 57 83

Genf-Cointrin

ELISA, Permanence Aéroport, Case postale 110, 1211 Genève 7,

Tel. 022 733 82 62, Fax 022 733 82 47

Кантон дахь хаягийг энд үзнэ үү: <http://www.fluechtlingshilfe.ch/aide/adresses-utiles>

6. Ерөнхий мэдээлэл

Хуулийн зөвлөлгөө, өмгөөлөгч

Та өөрөө өөрийн хуулийн тус дэмжлэгтээ санаа тавих ёстой. Тусламжийн-байгууллагуудын дэрэгдэх хуулийн зөвлөлгөө өгдөг газруудын хаягийг энэ вэбсайтад үзнэ үү: <http://www.for-refugees.ch/> эсвэл тусгай хаягийн хуудаснаас харна уу.

Гэр бүлээ татах, гэр бүлээ нэгдээх

Цагаач гэр бүлийн гишүүдээ эх ороноосоо татаж авчрах эрх байхгүй.

Нийгмийн тусламж, яалтгүй байдлын тусламж

Шаардлагатай тохиолдолд орогнол эрэгчийг түүний цагаачлах асуудлыг шалгах явцад нийгмийн халамжийн тэтгэлэгт хамруулна.

Швейцарын үндсэн хууль (12 дугаар зүйл) Швейцард амьдарч байгаа бүх хүнд гачаалалтай үед нь тусламж ба асрамж амалдаг. Таньд цагаачлалын сөрөг шийдвэр гарсан ба тэр байтугай та Швейцар улсад хууль бусаар байгаа ч гэсэн гаран гартлаа таньд **яалтгүй байдлын тусламж авах эрх** бий. Энэ түргэн тусламжид: хоол, орон байр, хувцас ба хүнд үед өгөх эмнэлгийн түргэн тусламж орно. Энэ тусламжийг авахын тулд та таны биеийн байцаалт, бичиг баримтыг хариуцсан албан байгууллагуудад мэдэгдэх ёстой тул таньд баривчлагдах аюул бий. Үргэжлэл мэдээлэлийг энэ вэбсайтад үзнэ үү: <http://www.for-refugees.ch/>

Хөдөлмөр эрхлэх

Швейцарын албан байгууллагууд цагаачдад эхний 3 аас 6 сард хөдөмөр эрхлэхийг хорьдог. Дараа нь ажиллах эрх өгдөг боловч цөөхөн салбар нээлттэй байх ба нутгийн ажилчидаа эхэлж авдаг.

Оршин суух

Та нүүх болгондоо хаягаа албан байгууллагуудад мэдээлэх ёстой. Цагаач өөрөө муж улсаа солих эрхгүй.

Баривчлах, шорон

Та хуулиар баривчлагдах магадлалтай, хэрэв:

- Таныг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гарсан тохиолдолд.
- та албан байгууллагуудтай хамтран ажиллахаас татгалзвал.
- таны орогнол хайлт «хуурамчаар ашиглаж байна» гэж тогтоогдвол.
- та хуулийн ялтан болвол.
- таныг нутагт тань буцаахад таны зүгээс эсэргүүцэл үзүүлэх тодорхой шинж тэмдэг байвал.

Гадаадад аялах

Та орогнох хүсэлтийг шалгах үйл ажиллагааны явцад Швейцараас гарах эрхгүй ба өөрийн улсын консулат ба албан байгууллагуудтай холбоо барьж болохгүй.